



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 212

Улаанбаатар хот

“Буян” ХК-ийн зарим үнэт цаасны
өмчлөх эрхийг шилжүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 162 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бусдад бэлэглэх, өвлүүлэх тухай журам”-ын 1.12, 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн, “Буян” ХК-ийн үнэт цаасны арилжааг Хорооны шийдвэрээр зогсоосон байгааг тэмдэглэн, Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Энэ тогтоолын хавсралтад дурьдсан нэр бүхий 4 иргэний өмчлөлийн “Буян” ХК-ийн нийт 2,538 ширхэг энгийн хувьцааг өмчлөх эрхийг тэдгээрийн гаргасан хүсэлтийн дагуу тус компанийн хувьцаа эзэмшигч Х.Бахтиярт шилжүүлэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д зөвшөөрсүгэй.

2. Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бэлэглэлийн журмаар шилжүүлэх ажиллагааг холбогдох журмаар тогтоосон нөхцөл шаардлага, нотлох баримтын бүрдэл, үйлчилгээний шимтгэлийн дагуу гүйцэтгэхийг “ҮЦТТТХТ” ХХК/Т.Гандулам/-д даалгасугай.

3. Тогтоолын биелэлтэд нь хяналт тавьж, ажиллахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.


ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000368

Санхүүгийн зохицуулах хорооны
2013 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн
212 дугаар тогтоолын хавсралт



"Буян" ХК-ийн хувьцаагаа бусдад шилжүүлсэн иргэдийн жагсаалт

№	Бэлэглэлийн гэрээний огноо	Нотариатчийн баталгаажуулалт	Бэлэглэгч	Бэлэг хүлээн авагч	Хувьцааны тоо ширхэг
5.	2010.05.18	2010.05.18	Б.Шугатай ПЭ47122819 21-172067	Х.Бахтияр 21-250378 ПЭ38070135	776
6.	2010.05.10	2010.09.21	Д.Бавуусүрэн ПЮ36070579 21-172083	Х.Бахтияр ПЭ38070135 21-250378	1420
7.	2010.05.24	2010.05.25	Ц.Буянтогтох ПЭ60092506 21-1724041	Х.Бахтияр ПЭ38070135 21-250378	140
8.	2010.05.20	2010.05.26	Д.Оюунчимэг ПЭ38070135 21-172009	Х.Бахтияр ПЭ38070135 21-250378	202
Нийт					2538

--оо00оо--